Дугаар 4-42

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн ХХ-08-01 дүгээр дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймгийн Булган сумын нутагт орших XV-65000022 тоот тусгай зөвшөөрөлтэй Авхайн булаг элс-хайрганы холимгийн ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь элс-хайрганы холимгийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 299,746.4 м<sup>3</sup>, үүнээс хайрга 206,825.1 м<sup>3</sup>, элс 92,921.5 м<sup>3</sup>, боломжтой (С) зэрэглэлээр 235,131.5 м<sup>3</sup>, үүнээс хайрга 162,240.6 м<sup>3</sup>, элс 72,890.9 м<sup>3</sup>, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 534,877.3 м<sup>3</sup> үүнээс хайрга 369,065.7 м<sup>3</sup>, элс 165,812.4 м<sup>3</sup>-ээр хүлээн авсугай.

2. Хүлээн авсан геологийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Гео-мэдээллийн төв /Ц.Минжинсор/-д зөвшөөрсүгэй.

3. Архангай аймгийн Булган сумын нутагт орших XV-65000022 тоот тусгай зөвшөөрөлтэй Авхайн булаг элс-хайрганы холимгийн ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг бичвэр дискийн хамт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан Үндэсний Геологийн Албаны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивд хүлээлгэн өгөхийг "Бодь Ар" ХХК (Т.Алтангэрэл)-д даалгасугай.



ДАРГА

О.ЧУЛУУН

182201 334





УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2022 оны 05 дугаар сарын 06

№ ХХ-08-01

Улаанбаатар хот

Архангай аймгийн Булган сумын нутагт орших  
Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордод 2022 онд  
гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн  
тайланг хэлэлцсэн тухай

Архангай аймгийн Булган сумын нутагт орших Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр Монгол Улсын мэргэшсэн геологич С.Энхтуяа, геологич Б.Азбаяр, П.Ган-Эрдэнэ, О.Дашцэрэн, О.Ганчимэг, уулын инженер Л.Чинзориг нарын боловсруулсан тайлан, уг тайлан болон ордын нөөцийн тооцоонд Монгол Улсын мэргэшсэн геологич Ц.Пунцагдуламын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна. Үүнд:

1. Архангай аймгийн Булган сумын нутагт орших “Авхайн булаг” нэртэй, 140.25 га талбай бүхий XV-65000022 (2021/002X) тоот тусгай зөвшөөрлийг Архангай аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/865 тоот захирамжаар “Бодь Ар” ХХК-д анх олгосон.

Тусгай зөвшөөрөлтэй талбай нь Улаанбаатар хотоос 480 км, Архангай аймгаас зүүн урагш 7 км, Булган сумаас зүүн хойш 36 км-т байрладаг.

2. “Бодь ар” ХХК нь 2022 онд хайгуулын ажил гүйцэтгэж, элс-хайрганы холимогийн ордын нөөцийг бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр тооцоолж, хайгуулын ажилд нийт 29,957,050.0 төгрөг зарцуулсан байна.

3. Тус дүүрэгт 1974-1975 онд Т.Намсрай нар 1:25000-ны масштабын эрлийн ажил, 1980-1982 онд 1:200000-ны масштабын геологийн зураглалын ажил, 1986-1990 онд С.Гүрцөө, Д.Тилеу, Ш.Ренчиндорж, н.Балжинням, Б.Төмөр нарын Зүүнхангайн /L-47-V, VI, XII хавтгай/ хэмжээнд 1:200000-ны масштабтай геологи, эрэл-зураглалын ажил хийж гүйцэтгэжээ.

4. “Бодь ар” ХХК нь хайгуулын ажлыг 100x100 м-ийн торын нягтралаар Hyundai ROBEX1300W маркийн эксковатораар хайгуулын 5 шугаманд, дундажаар 3.2 м-ийн гүнтэй 17 шурф буюу нийт 56.0 т.м шурф нэвтрэлтийн ажил хийж, ордын элс-хайрганы холимогийн чанарын үнэлгээг физик-механикийн бүрэн шинжилгээг шигшсэн элсний 3 дээж, хайрганы 3 дээж, физик-механикийн хураангуй шинжилгээг шигшсэн элсний 8 дээж, хайрганы 8 дээж, бетоны найрлага тогтоох туршилтыг 1 дээж, химийн шинжилгээг элсний

2 дээж, хайрганы элэгдэл тодорхойлох шинжилгээг 2 дээж, хайрганы урвалжих чадвар тодорхойлох шинжилгээг 2 дээж, хайрганы сульфат тэсвэрлэлт буюу хүйтэн тэсвэрлэлтийн шинжилгээг 2 дээж, цацраг идэвхжилийн 1 дээж, петрографийн бүрэн бичиглэл 2 дээж, химийн шинжилгээ 2 дээжинд тус тус шинжилгээнд хамруулжээ.

1:2000-ны масштабтай байрзүйн зураглал, хайгуулын малталтуудын байр зүйн холболт, олборлогдсон карьер, талбайн хэмжилтийг “Эн Эс Эй” ХХК, сорьцын шинжилгээний ажлуудыг “Барилга архитектур корпорац” ХХК-ийн Сорилтын лаборатори (БАК), цацраг идэвхжилийн ажлыг МУИС-ийн Цөмийн физикийн судалгааны төвийн лаборатори, петрографийн бүрэн шинжилгээ, химийн шинжилгээг “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-аар гүйцэтгүүлсэн байна.


5. Тус орд нь урд Тамирын голын хуучин хөндийд байх ба түүний урсгалын дагуу зүүн урдаас баруун тийш сунаж тогтсон. Орд нь плейстоцен-голоцен (Q<sub>1-2</sub>)-ны настай, 860 м урт, 260 м өргөн хуримтлал үүсгэсэн хурдсаас тогтоно.

Ордыг бүрдүүлж байгаа хурдас нь бүхэлдээ голын алкови-пролювийн хурдас болох элс-хайрганы холимогоос тогтох бөгөөд эдгээр нь ерөнхийдээ нэг төрлийн жигд найрлагатай, хайрганууд нь харавтар саарал, хөхөвтөр саарал өнгөтэй, элс-хайрганы холимог нь гадаргын хэлбэршилийн дагуу налуувтар тархсан байна.

Ордын элс-хайрганы холимгийн хайрга нь ширхэгийн найрлагын хувьд нийт талбайн хэмжээндээ харавтар ба хөхөвтөр саарал өнгөтэй элсэн чулуу, элсэн чулуу-алевролит, аргиллит, хөрсөн чулуу, хар хар ногоон өнгийн базальт, андезибазальтын хайргаас бүрдэх ба элс нь кварц-хээрийн жоншны найрлагатай. Хайрганы хэмжээ нь 5-70 мм-т хэлбэлзэх ба 70 мм түүнээс том хэмжээтэй бул чулууны агуулга нь 4.2-21.2%-д хэлбэлзэх ба ордын хэмжээнд дунджаар 14.2% байна. Хайрганууд нь их төлөв өнцөглөг багатай, зөв хэлбэртэй, дунд сайн мөлгөржсөн, ихэнхдээ бараг гайгүй мөлгөржсөн гадаргуу нь мөлгөрдүү байна. Элс нь кварц-хээрийн жоншны найрлагатай, жижиг ширхэгтэй ерөнхийдөө цэвэр, шаварлаг ба тоосорхог хэсэг бага зэрэг агуулсан, органик хольцгүй. Элс-хайрганы холимгийн давхрага нь, нийт талбайдаа дээгүүрээ 0.0-0.1 м хүртэл дунджаар 0.03 м зузаантай элсэнцэр, хөрс ургамлын үеэр хучигдсан. Элсэнцэр нь шаравтар саарал өнгөтэй, маш жижиг ширхэгтэй бохирдол ихтэй байна.

6. Ордын элс-хайрганы хольц дахь хайрганы агууламж 64.7.2-74.6% дундажаар 69.0%, 5 мм-ээс жижиг хэсэг буюу элсний агууламж 25.4-35.3% дундажаар 31.0%. Холимогоос ялгасан хайрганы ширхэгийн бүрэлдэхүүний үзүүлэлтээр 70 мм-ээс том хэсэг 4.2-21.2% дундажаар 14.2%, 40-70 мм ширхэглэлтэй хэсэг 39.2-45.1% дундаж нь 41.7.1%, 20-40 мм ширхэглэл 15.1-25.7% дундажаар 20.9%, 10-20 мм ширхэглэлтэй хэсэг нь 10.6-18.2%, дундажаар 13.7%, 5-10 мм ширхэглэлтэй хэсэг нь 1.4-13.8%, дундажаар 9.5%. 40 мм-ээс том хэсгийг ялган ангилсаны дараа буталж хэрэглэнэ. Хайрганы нимгэн үзүүлэг хэсэг нь 0.5-1.3%-ийн хооронд хэлбэлзэж дундаж нь 0.9% байгаа нь Б-8 маркийн (15% хүртэл) хайрганы шаардлага хангах бөгөөд MNS 0346:2000 стандартын 3.4.2-д заасан шоо хэлбэрийн хайрганы ангилалд багтана. Тоос шавар шорооны хольцын агуулга 0.4-0.6% хооронд хэлбэлзэж дундажаар 0.5% байна.

*Хольцоос шигшиж ялгасан элс:* Элсний ширхэгийн торниуны (модуль) үзүүлэлт 2.50-2.87 дундажаар 2.72 байгаа нь дунд зэргийн ширхэглэлтэй элсний ангилалд багтах бөгөөд бетонд хэрэглэх жижиг дүүргэгчийн шаардлага (Mк-2.1-3.25)-ыг хангана.



Ширхэгийн бүрэлдэхүүний үзүүлэлтээр 2.5-5 мм ширхэглэлтэй хэсэг 15.4-21.3 % дунджаар 18.4 %, 1.25-2.5 мм ширхэглэлтэй хэсэг 10.0-18.2 % дунджаар 14.4 %, 0.63-1.25 мм хэсэг 10.5-25.3 % дундаж нь 17.9% 0.315-0.63 мм хэсэг нь 22.6-31.2 % дунджаар 27.5 %, 0.14-0.315 мм ширхэглэлтэй хэсэг нь 8.9-25.4% дунджаар 14.1%, 0.14 мм-ээс бага хэсэг нь 2.0-10.9% дунджаар 7.7 % байна. 0.63 мм шигшүүр дээрхи нийлбэр үлдэцийн дундаж үзүүлэлт 50.6 % байгаа нь тухайн ангилалын элсэнд тавих хязгаар (35%-иас их)-т байгаа ба бусад шигшүүр дээрхи нийлбэр үзүүлэлтээр MNS 2804:2004 станадартын 4.2.2 заалтын бетонд хэрэглэх элсний ширхэгийн бүрэлдэхүүнд тавих шаардлагыг хангаж байна.

Элсэнд агуулагдах 0.14 мм-ээс жижиг хэсгийн агуулга 2.0-10.9% дундажаар 7.7% байгаа нь мөн стандартын шаардлагын хязгаарт /10%-иас бага/ багтаж байна. Элсэн дахь тоос, шавар шорооны агууламж 3.0-4.2%, дундажаар 3.5 байгаа нь “Барилгын ажилд хэрэглэх элс-хайрганы хольц. Техникийн ерөнхий шаардлага” MNS 3089:1998-ийн 2.9-ийн шаардлага (<5%)-ын хязгаарт байгаа боловч “Барилга байгууламжийн ажилд хэрэглэх элс. Техникийн ерөнхий шаардлага” MNS 0392:2014 стандартын 4.4.1-д заасан дунд ширхэглэлтэй элсний стандартын шаардлага 3.0% -иас бага зэрэг их байгаа тул элсийг угааж баяжуулсаны дараа бетонд хэрэглэх шаардлагатай.

Элсэнд бүхэл шавар агуулагдаагүй бөгөөд калорометрийн аргаар идэмхий натрийн уусмалтай харьцуулан тодорхойлсон органик хольцын агууламжаар стандартын шаардлага хангана.


Дээжид ирүүлсэн элс, хайрганы химийн шинжилгээний үр дүнгээс харахад  $\text{SiO}_2$ -73.86-75.08;  $\text{Al}_2\text{O}_3$ -12.87-12.91%;  $\text{Fe}_2\text{O}_3$ -3.14-3.19%;  $\text{CaO}$  1.87-2.41%,  $\text{MgO}$ - 2.09-2.10%;  $\text{K}_2\text{O}$ -1.40-1.42 %,  $\text{Na}_2\text{O}$ -1.47 -1.53%,  $\text{S}_0_3$  0.23-0.27% тус тус агуулж, шатаахад гарах хорогдол (ШГХ)-1.74-2.38 % байна.

Ордын элс-хайрганы холимог нь MNS 3089:1998 “Барилгын ажилд хэрэглэх элс-хайрганы хольц. Техникийн ерөнхий шаардлага”, MNS 2803:2004 “Хүнд бетонд хэрэглэх дүүргэгч материал. Техникийн шаардлага” стандартаар зам, барилгын ажилд 350 хүртэл маркийн бетонд элсийг угааж баяжуулан орц, найрлагыг тогтоолгосоны үндсэн дээр мөн барилгын бусад төрлийн ажилд асгаас байдлаар хэрэглэх бүрэн боломжтой гэж үзжээ.

7. Зохиогчид ордыг 2-р бүлгийн ордод хамааруулж, ордын нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 299,746.4 м<sup>3</sup>, үүнээс хайрга 206,825.1 м<sup>3</sup>, элс 92,921.5 м<sup>3</sup>, боломжтой (C) зэрэглэлээр 235,131.5 м<sup>3</sup>, үүнээс хайрга 162,240.6 м<sup>3</sup>, элс 72,890.9 м<sup>3</sup>, нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 534,877.9 м<sup>3</sup>, үүнээс хайрга 369,065.7 м<sup>3</sup>, элс 165,812.4 м<sup>3</sup>-ээр тооцоолсон байна.

Шинжээч дээрх нөөцийн тооцоонд хяналтын тооцоо хийж, ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүлээн авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ордын нөөцийг шинжээчийн санал болгосон зохиогчдын тооцоолсон хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн санд бүртгэх, тайланд засвар хийлгэх нь зүйтэй гэж үзсэн байна.

8. 1983 онд Урд Тамирын голын хөндийд явуулсан газрын доорх усны нарийвчилсан хайгуулын судалгаагаар ус агуулагч давхаргын гүний байрлалын дээд зааг буюу газрын доорх ус нь түрлэггүй, чөлөөт гадаргуутай, усны тогтонги түвшин 4.58-6.07 м. Тус нөөцийн тооцооны тайланд элс хайрганы ил уурхайн дундаж гүн нь 3.5 м байна гэж тусгасан байна. Уулын малталтанд газрын доорх ус шүүрэн орж ирээгүй гэжээ.



9. Урьдчилсан эдийн засгийн тооцоогоор нийт 1,373.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт оруулж, ордын нэг куб.м шигшиж ялгасан бүтээгдэхүүнийг 25.0 мян.төг/м<sup>3</sup> борлуулахад жилд 13,727.7 сая төгрөгийн орлого олох ба үйлдвэрийн зардал болон бүх төрлийн татвар төлсний дараах цэвэр ашиг нь 4,909.15 сая төгрөг болно. Хөрөнгө оруулалтыг 1.7 жилд нөхөх тооцоо хийсэн байна.

10. Цаашид түүхий эдийн чанарт хяналт тавьж ажиллах, байгаль орчны нөхөн сэргээх үйл ажиллагаанд анхаарч ажиллах, геоэкологийн судалгаа хийлгэх, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, холбогдох хууль тогтоомж, ялангуяа “Ашигт малтмалын тухай” хууль болон “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай” хууль тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

*Нөөцийн тооцоонд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3, 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, 45.3 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Үндэсний геологийн албаны даргад уламжлахаар шийдвэрлэв. Үүнд:*


Нэг. “Архангай аймгийн Булган сумын нутагт орших Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” (Ордын нөөц 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар) дахь элс-хайрганы холимогийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр 299,746.4 м<sup>3</sup>, үүнээс хайрга 206,825.1 м<sup>3</sup>, элс 92,921.5 м<sup>3</sup>, боломжтой (С) зэрэглэлээр 235,131.5 м<sup>3</sup>, үүнээс хайрга 162,240.6 м<sup>3</sup>, элс 72,890.9 м<sup>3</sup>, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр 534,877.9 м<sup>3</sup>, үүнээс хайрга 369,065.7 м<sup>3</sup>, элс 165,812.4 м<sup>3</sup>-ээр энэхүү дүгнэлтийн хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

Хоёр. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан элс-хайрганы холимогийн нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг УГА-ны Геомэдээллийн төв (Ц.Минжинсор)-д зөвшөөрөх.

Гурав. Энэхүү дүгнэлтийн 10 дугаарт заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Бодь Ар” ХХК (Т.Алтангэрэл)-д анхааруулах.

Дөрөв. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч материалууд, тайлангийн бичвэрийн дисккийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан УГА-ны даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг “Бодь Ар” ХХК (Т.Алтангэрэл)-д даалгах.

Тав. “Архангай аймгийн Булган сумын нутагт орших Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордод 2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан” боловсруулалтыг Монгол Улсын мэргэшсэн геологич С.Энхтуяа, геологич Б.Азбаяр, П.Ган-



Эрдэнэ, О.Дашцэрэн, О.Ганчимэг, уулын инженер Л.Чинзориг нар, шурф малгалтын ажлыг “Бодь Ар” ХХК, лабораторийн шинжилгээний ажлын үр дүнг “Барилга Архитектур Корпораци” ХХК-ийн Сорилтын лаборатори, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ, 1:2000-ны масштабын байрзүйн зураглалын ажлыг “Эн Эс Эй” ХХК тус тус хариуцах, тайлан, түүн дэх ордын нөөцийн тооцоонд гаргасан шинжээчийн дүгнэлтийг Монгол Улсын мэргэшсэн геологич Ц.Пунцагдулам, хайгуулын ажлын үнэн бодит байдлыг “Бодь Ар” ХХК тус тус хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН САЛБАР

ХУРАЛДААНЫ ДАРГА

А.ДЭЛГЭРСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА

Б.МӨНХ-ЭРДЭНЭ

ЭБМЗ-ийн *dodd* оны *05* дугаар сарын *06*-ны өдрийн хуралдааны  
*XX-08-01* дугаар дүгнэлтийн хавсралт

Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордын нөөцийн нэгдсэн хүснэгт  
 (Ордын нөөц 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар)  
 Тусгай зөвшөөрлийн дугаар XV-65000022 (2021/002X)

Хүснэгт №1

Хэсэглэ- л-ийн дугаар	Хэсэглэл- ийн талбай, м <sup>2</sup>	Ашигт малтмал ын зузаан,м	Хөрсни й зузаан, м	Ашигт малтмалын нөөц, м <sup>3</sup>			Хучаас хөрсний зузаан, м <sup>3</sup>
				Элс- хайрганы холимог	Элс - 31 %	Хайрга- 69 %	
В-1	21724.08	3.20	0.03	69517.05	21550.3	47966.8	651.7
В-2	14137.05	3.20	0.04	45238.57	14024.0	31214.6	565.5
В-3	16450.96	3.34	0.04	54946.21	17033.3	37912.9	658.0
В-4	19897.82	3.28	0.03	65331.17	20252.7	45078.5	596.9
В-5	19911.82	3.25	0.03	64713.42	20061.2	44652.3	597.4
С-1	12717.44	3.23	0.03	41119.72	12747.1	28372.6	381.5
С-2	5138.86	3.05	0.05	15673.52	4858.8	10814.7	256.9
С-3	5015.75	3.05	0.10	15298.04	4742.4	10555.6	501.6
С-4	4875.13	3.05	0.00	14869.15	4609.4	10259.7	0.0
С-5	4795.94	3.25	0.10	15586.81	4831.9	10754.9	479.6
С-6	5740.10	3.20	0.00	18368.32	5694.2	12674.1	0.0
С-7	5657.77	3.35	0.10	18953.53	5875.6	13077.9	565.8
С-8	3552.15	3.35	0.00	11899.70	3688.9	8210.8	0.0
С-9	5285.64	3.20	0.10	16914.05	5243.4	11670.7	528.6
С-10	4846.23	3.25	0.00	15750.25	4882.6	10867.7	0.0
С-11	4472.01	3.25	0.10	14534.03	4505.6	10028.5	447.2
С-12	10849.32	3.33	0.03	36164.40	11211.0	24953.4	325.5
<b>В</b>	<b>92,121.73</b>			<b>299,746.42</b>	<b>92,921.5</b>	<b>206,825.1</b>	<b>3,069.5</b>
<b>С</b>	<b>72,946.34</b>			<b>235,131.52</b>	<b>72,890.9</b>	<b>162,240.6</b>	<b>3,486.7</b>
<b>В+С</b>	<b>165,068.07</b>			<b>534,877.94</b>	<b>165,812.4</b>	<b>369,065.7</b>	<b>6,556.2</b>
<b>Ордын дундаж</b>		<b>3.24</b>	<b>0.04</b>				



АШИГТ МАЛТМАЛ,  
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 10 сарын 24 өдөр

Дугаар Т/188

Улаанбаатар хот

Техник, эдийн засгийн үндэслэл  
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн т/22-09-25 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-65000022 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Бодь ар ХХК-ийн "Авхайн булаг" нэртэй элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.

2. Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-65000022 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Авхайн булаг" нэртэй элс-хайрганы холимгийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник, эдийн засгийн үндэслэлийг хуулсан дискийг Уул уурхайн хэлтэст хүлээлгэн өгөхийг Бодь ар ХХК-д даалгасугай.

ДАРГА



Л.БАЯРМАНДАЛ

53711337



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ  
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР  
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН  
ДҮГНЭЛТ

2022 оны 09 дугаар сарын 15

№ 7/22-09-25

Улаанбаатар хот

Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-65000022 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник-эдийн засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

"Бодь ар" ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК боловсруулсан Архангай аймгийн Булган сумын нутагт орших Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник-эдийн засгийн үндэслэлд Монгол улсын зөвлөх инженер Л.Жаргалсайхан зөвлөж, Уул уурхайн мэргэшсэн инженер Д.Ариунболд шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074 дүгээр тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам"-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник-эдийн засгийн үндэслэл нь уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн эдийн засгийн гол үзүүлэлтүүд, Танилцуулга, Ордын ерөнхий мэдээлэл, Ордын геологийн судалгаа, Олборлолт, Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэсэг, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Уурхайн үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, Төслийн эдийн засаг зэрэг 10 бүлэг, Дүгнэлт, Ашигласан материал бүхий 158 хуудас тайлбар бичиг, 17 хавсралт зургаас бүрдэж байна.
4. Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордын MV-65000022 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн хурлын ХХ-08-01 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан ҮГА-ны даргын 2022 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Н-42 тоот тушаалаар



бодитой В зэрэглэлээр 299.75 мян.м<sup>3</sup>, боломжтой С зэрэглэлээр 235.13 мян.м<sup>3</sup>, нийт бодитой болон боломжтой В+С зэрэглэлээр 534.88 мян.м<sup>3</sup> гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд ил уурхайн хаягдлыг 3.07% буюу 9.42 мян.м<sup>3</sup> элс-хайрганы холимог, бохирдлыг 3.0% буюу 9.21 мян.м<sup>3</sup> байхаар тооцож геологийн бодитой В болон олборлолтонд өртөж буй боломжтой С зэрэглэлийн нөөцийг магадласан В' үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн тооцсоноор 306.48 мян.м<sup>3</sup> элс-хайрганы холимог олборлохоор тооцжээ. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 12.59 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 70.0 мян.м<sup>3</sup> элс-хайрганы холимог олборлох хүчин чадлаар нийт үйлдвэрлэлийн нөөцийг 5 жилийн хугацаанд ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын нөөцийн тогтоц болон байршил, хөрсний зузаан, эдийн засгийн үр ашиг зэргийг харгалзан үзэж ил аргаар авто тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд Doosan Dх 300 маркийн экскаватор 1 ширхэг, Howo 336 маркийн автосамосвал 2 ширхэг, XCMG ZL 50 маркийн утгуурт ачигч 1 ширхэг, Foton маркийн усны машин 1 ширхэг, Daewoo маркийн түлшний машин 1 ширхэг, 60 м<sup>3</sup>/цагийн хүчин чадал бүхий бетон зуурмагийн үйлдвэр, бутлан ангилах хэсэгт PE-500x750 маркийн хацарт бутлуур 1 ширхэг, PCL 1500 маркийн алхан бутлуур 1 ширхэг, SZZ 1645 маркийн чичиргээт шигшүүр 1 ширхэг, YA1236 маркийн чичиргээт шигшүүр 1 ширхэг зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар төлөвлөжээ.

8. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэсэг нь бутлан ангилах болон бетон зуурмаг үйлдвэрлэх гэсэн 2 хэсэгтэй байхаар төлөвлөжээ. Бутлан ангилах хэсгийн технологийг захиалагч талаас өгсөн техникийн даалгавар болон "Барилга архитектур корпораци"-ийн бетон дүүргэгчийн лабораторид хийлгэсэн туршилт шинжилгээний үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Бутлан ангилах хэсгийн хүчин чадал 70.0 мян.м<sup>3</sup>/жил байна. Бетон зуурмагийн үйлдвэр нь эхний жилд 5.0 мян.м<sup>3</sup>, 2 дахь жилээс жилд 10.0 мян.м<sup>3</sup> М350 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэхээр тооцжээ.

9. Авхайн булаг элс-хайрганы холимогийн уурхайн цахилгаан ачаалал 302.81 кВт бөгөөд хэрэглэгчдийг ЭБЦТС ТӨХК-ийн Архангай салбараас 10/0.4 кВ хүчдэлтэй 400 кВА-ын суурилагдсан хүчин чадалтай дэд станц угсарч ЦЭХ-ээр хангахаар тооцжээ. Тус уурхайн унд-ахуйн болон технологийн усны хэрэгцээнд 35.92 мян.м<sup>3</sup> ус шаардлагатай бөгөөд үүнээс ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 0.95 мян.м<sup>3</sup> ус, зам усалгаанд 1.7 мян.м<sup>3</sup> ус, ногоон байгууламжийн усалгаанд 17.21 мян.м<sup>3</sup> ус, бетон зуурмагийн үйлдвэрт 8.64 мян.м<sup>3</sup> ус, мод усалгаанд 8.64 мян.м<sup>3</sup> ус ашиглахаар тооцжээ. Ордын шаардлагатай унд-ахуйн болон технологийн усны хэрэгцээг гүний худаг ерөмдөн хангахаар тусгажээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 266.64 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 84.3 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 42.83 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 69.14 сая төгрөг, төслийн хаалтын зардалд 62.60 сая төгрөг, хаалтын дараах хяналтын зардалд 7.77 сая төгрөгийг тус тус зарцуулахаар тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлсэнээр 43 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,720.0 мянган төгрөг байхаар байна.

12. Төсөл хэрэгжүүлэхэд анхны хөрөнгө оруулалт нийт 2,843.10 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс ил уурхайн техник хэрэгслийн хөрөнгө оруулалт 1,135.20 сая төгрөг, бутлан ангилах хэсгийн хөрөнгө оруулалт 220.50 сая төгрөг, бетон зуурмагийн үйлдвэрийн хөрөнгө оруулалт 871.50 сая төгрөг, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт 120.75 сая төгрөг, тавилга эд хогшил, тохижилтонд 36.17 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 210.0 сая төгрөг, биет бус хөрөнгө оруулалт 60.00 сая төгрөг, ажлын капитал зардалд 98.83 сая төгрөг бөгөөд ашиглалтын хугацаанд нэмэлт хөрөнгө оруулалтын хэмжээ 54.26 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал ашиглалтын хугацаанд 1,633.03 сая төгрөг байхаар тооцоолжээ.

13. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 12,735.20 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 17,020.83 сая төгрөгийн борлуулалт хийж, 2,864.69 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 2,548.64 сая төгрөгийн цэвэр ашигтай, 4,315.54 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 2,765.42 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд 1 м<sup>3</sup> элс-хайрганы бүрэн өөрийн өртөг 12,136 төгрөг, 1 м<sup>3</sup> бетон зуурмагийн бүрэн өөрийн өртөг 192,083 төгрөг байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 4,315.54 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 1,154.39 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 21%, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 3.6 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
4. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангах ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.
5. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн "Цариг ресурс" ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Уул уурхайн мэргэшсэн инженер Д.Ариунболд тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. "Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-6500022 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник-эдийн засгийн үндэслэл"-ийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд дахин тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-6500022 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордыг ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх техник-эдийн засгийн үндэслэл, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН  
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ

**“Бодь ар” ХХК-ийн Архангай аймгийн Булган сумын нутагт орших MV-6500022 тоот ил аргаар ашиглан бетон зуурмаг үйлдвэрлэх төслийн техни**

Блокын дугаар	Геологийн нооц						Ил уурхайн хүрээний гадна үлдэх нооц									
	Блокын талбай	Хөрсний зузаан	Ашигт малтмалын зузаан	Хөрсний эзлэхүүн	Ашигт малтмалын нооц	Элс, 31%	Хайрга, 69%	Блокын талбай	Хөрсний зузаан	Ашигт малтмалын зузаан	Хөрсний эзлэхүүн	Ашигт малтмалын нооц	Элс, 31%	Хайрга, 69%	Блокын талбай	
Х.нэгж	мян.м <sup>2</sup>	м	м	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>2</sup>	м	м	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.м <sup>3</sup>	мян.	
B-1	21.72	0.03	3.20	0.651	69.51	21.55	47.96								21.7	
B-2	14.13	0.04	3.20	0.565	45.23	14.02	31.21								14.1	
B-3	16.45	0.04	3.34	0.658	54.94	17.03	37.91								16.4	
B-4	19.89	0.03	3.28	0.596	65.33	20.25	45.07								19.8	
B-5	19.91	0.03	3.25	0.597	64.71	20.06	44.65								19.9	
<b>Нийт (B)</b>	<b>92.12</b>	<b>0.03</b>	<b>3.25</b>	<b>3.06</b>	<b>299.74</b>	<b>92.92</b>	<b>206.82</b>								<b>92.1</b>	
C-1	12.71	0.03	3.23	0.381	41.11	12.74	28.37	12.44	0.03	3.23	0.373	40.22	27.75	12.43	0.27	
C-2	5.13	0.05	3.05	0.256	15.67	4.8	10.81	5.00	0.05	3.05	0.250	15.25	10.52	4.99	0.13	
C-3	5.01	0.10	3.05	0.501	15.29	4.74	10.55	4.87	0.10	3.05	0.487	14.87	10.26	4.87	0.13	
C-4	4.87	-	3.05	-	14.86	4.60	10.25	4.65	-	3.05	-	14.19	9.79	4.65	0.22	
C-5	4.79	0.10	3.25	0.479	15.58	4.83	10.75	4.64	0.10	3.25	0.465	15.11	10.43	4.64	0.14	
C-6	5.74	-	3.20	-	18.36	5.69	12.67	5.58	-	3.20	-	17.88	12.34	5.58	0.15	
C-7	5.65	0.10	3.35	0.565	18.95	5.87	13.07	5.45	0.10	3.35	0.545	18.26	12.60	5.44	0.20	
C-8	3.55	-	3.35	-	11.89	3.68	8.21	3.38	-	3.35	-	11.34	7.82	3.38	0.16	
C-9	5.28	0.10	3.20	0.528	16.91	5.24	11.67	5.11	0.10	3.20	0.511	16.38	11.30	5.11	0.16	
C-10	4.84	-	3.25	-	15.75	4.88	10.86	4.70	-	3.25	-	15.30	10.56	4.70	0.13	
C-11	4.47	0.10	3.25	0.447	14.53	4.50	10.02	4.336	0.10	3.25	0.433	14.09	9.72	4.33	0.13	
C-12	10.84	0.03	3.33	0.325	36.16	11.2	24.95	10.56	0.03	3.33	0.317	35.23	24.30	10.56	0.28	
<b>Нийт (C)</b>	<b>72.94</b>	<b>0.05</b>	<b>3.21</b>	<b>3.48</b>	<b>235.13</b>	<b>72.89</b>	<b>162.24</b>	<b>70.78</b>	<b>0.05</b>	<b>3.21</b>	<b>3.39</b>	<b>228.18</b>	<b>157.44</b>	<b>70.78</b>	<b>2.14</b>	
<b>Бүгд (B+C)</b>	<b>165.06</b>	<b>0.04</b>	<b>3.24</b>	<b>6.55</b>	<b>534.87</b>	<b>165.81</b>	<b>369.06</b>	<b>70.78</b>	<b>0.04</b>	<b>3.24</b>	<b>3.39</b>	<b>228.18</b>	<b>145.47</b>	<b>70.78</b>	<b>94.2</b>	

2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн ХХ-08-01 тоот ЭБМЗ-ийн дүгнэлт, 2022 орд тул боломжтой С зэрэглэлийн нөөцийг өртүүлж олборлоно. Уул уурхайн сайдын 2015 зэрэглэлийн нөөц, болон олборлолтонд өртөж байгаа боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг нь 306.48 мян.м<sup>3</sup> элс хайрганы холимог байна.

**Ашиглалтын үеийн хаягдал:**

Авхайн булаг элс-хайрганы холимгийн ордын тооцоонд хамгийн ихдээ 3.07 хувийн хаягдал үү уурхайн ашиглалтын догол нь 3.2 м, доголын хажуугийн өнцөг нь 50 градус байна.

**Ашиглалтын үеийн бохирдол:**

Элс-хайрганы холимгийн нөөц бодсон хэсгээс доош элс хайрга үргэлжилж байгаа бохирдуулагч чулуулгийн хэмжээ 9.21 мян.м<sup>3</sup> байна.

Үзүүлэлт гаргасан:

“Цариг Ресурс” ХХК-ийн

Уулын инженер: *[Signature]*



ЭБМЗ-ийн 06.09.25 дүгээр дүгнэлтийн хавсралт

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дахь Авхайн булаг элс-хайрганы холимогийн ордыг үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийн нэгдсэн хүснэгт

Ашиглалтын ноц				Ашиглалтын хаягдал				Бохирдолт			Үйлдвэрлэлийн ноц					
Хөрсний зузаан	Ашигт малтмалын зузаан	Хөрс хуулагт	Ашигт малтмалын ноц	Элс, 31%	Хайрга, 69%	Хаягдлын хувь	Тавинаас хангалт хаягдал	Нийт хаягдал	Бохирдолтын хувь	Улуунаас үрэгдэх чулуулаг	Бохирдуулалт оруулах	Х.д.м.ж	Хөрс хуулагт	Ашигт малтмалын ноц	Элс, 31%	Хайрга, 69%
0.03	3.20	0.651	69.51	21.55	47.96	3.13	2.17	2.17	3.13	2.17	2.17	В'	2.82	69.51	21.55	47.96
0.04	3.20	0.565	45.23	11.67	33.56	3.12	1.41	1.41	3.12	1.41	1.41	В'	1.97	45.23	14.02	31.21
0.04	3.34	0.658	54.94	14.17	40.77	2.99	1.64	1.64	2.99	1.64	1.64	В'	2.30	54.94	17.03	37.91
0.03	3.28	0.596	65.33	16.85	48.47	3.05	1.99	1.99	3.05	1.99	1.99	В'	2.58	65.33	20.25	45.07
0.03	3.25	0.597	64.71	16.69	48.01	3.08	1.99	1.99	3.08	1.99	1.99	В'	2.58	64.71	20.06	44.65
<b>0.03</b>	<b>3.25</b>	<b>3.06</b>	<b>299.74</b>	<b>80.94</b>	<b>218.79</b>	<b>3.07</b>	<b>9.21</b>	<b>9.21</b>	<b>3.07</b>	<b>9.21</b>	<b>9.21</b>		<b>12.28</b>	<b>299.74</b>	<b>92.92</b>	<b>206.82</b>
0.03	3.23	0.008	0.895	0.278	0.618	3.09	0.028	0.028				В'	0.036	0.868	0.269	0.599
0.05	3.05	0.006	0.415	0.129	0.286	3.28	0.014	0.014				В'	0.020	0.401	0.124	0.277
0.10	3.05	0.013	0.422	0.131	0.291	3.28	0.014	0.014				В'	0.028	0.408	0.127	0.282
-	3.05	-	0.672	0.209	0.464	3.28	0.022	0.022				В'	0.022	0.651	0.202	0.449
0.10	3.25	0.014	0.469	0.146	0.324	3.08	0.014	0.014				В'	0.029	0.455	0.141	0.314
-	3.20	-	0.482	0.150	0.333	3.13	0.015	0.015				В'	0.015	0.467	0.145	0.323
0.10	3.35	0.020	0.687	0.213	0.474	2.99	0.021	0.021				В'	0.041	0.667	0.207	0.460
-	3.35	-	0.553	0.172	0.382	2.99	0.017	0.017				В'	0.017	0.537	0.167	0.371
0.10	3.20	0.016	0.532	0.165	0.368	3.13	0.017	0.017				В'	0.033	0.516	0.160	0.356
-	3.25	-	0.444	0.138	0.307	3.08	0.014	0.014				В'	0.014	0.431	0.134	0.297
0.10	3.25	0.013	0.441	0.137	0.305	3.08	0.014	0.014				В'	0.027	0.428	0.133	0.295
0.03	3.33	0.008	0.933	0.289	0.644	3.00	0.028	0.028				В'	0.036	0.905	0.281	0.625
<b>0.05</b>	<b>3.21</b>	<b>0.094</b>	<b>6.95</b>	<b>2.15</b>	<b>4.79</b>	<b>3.10</b>	<b>0.215</b>	<b>0.215</b>					<b>0.318</b>	<b>6.73</b>	<b>2.08</b>	<b>4.64</b>
<b>0.04</b>	<b>3.24</b>	<b>3.16</b>	<b>306.69</b>	<b>83.104</b>	<b>223.59</b>	<b>3.07</b>	<b>9.42</b>	<b>9.42</b>	<b>3.00</b>	<b>9.21</b>	<b>9.21</b>		<b>12.59</b>	<b>306.48</b>	<b>95.00</b>	<b>211.47</b>

ны 05-р сарын 17-ны өдрийн Н-42 тоот тушаалаар батлагдсан нөөцийн дүгнэлтээр орд нь II бүлгийн ордын 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаалын 2-р бүлгийн 4-р зүйлийн дагуу бодитой (В) магадласан (В') үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэв. Ордын нийт магадласан В' үйлдвэрлэлийн нөөц

снэ гэж үзлээ. Таазны хэсгээс 0.1 м зузаантайгаар хаягдал үүсгэхээр тооцлоо. Ашиглалт явуулах үед

чир улнаас 0.1 м зузаантай бохирдуулж олборлоно. Ордын хэмжээнд бохирдлын хувь 3.0 % буюу

Хүлээн авсан,  
И.Э.Мөнгөнхүү  
2022.09.19

Танилцсан:

АМГТГ-ын металл бус ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөн, бүртгэл

хариуцсан мэргэжилтэн: ..... / Э.Мөнгөнхүү /



“БОДЬ АР” ХХК-Д

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,  
Цахим шуудан: contact@met.gov.mn,  
Цахим хуудас: www.met.gov.mn

2022.06.02 № 13/2092  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт  
хүргүүлэх тухай**

Танай байгууллагаас ирүүлсэн Архангай аймгийн Булган сумын нутагт орших XV-65000022 (2021/002X) тусгай зөвшөөрөлтэй “Авхайн булагийн элс-хайрганы ордыг ил аргаар ашиглах” төсөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-д заасан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг үндэслэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж 2022 оны 4 дүгээр улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт ... хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ

Г.ЭНХМӨНХ

152274073

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС**

2022 оны 05-р сарын 30

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2022/ОА-75

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:** “БОДЬ АР” ХХК, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Элизабет 221, 229 тоот.

**Холбоо барих утас, И-мэйл хаяг:** +976- 99742200

**Төслийн нэр:** Архангай аймгийн Булган сумын нутагт орших XV-65000022 /2021/002X/ тусгай зөвшөөрөлтэй “Авхайн булагийн элс-хайрганы ордыг ил аргаар ашиглах” төсөл.

**Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:** Архангай аймгийн Булган сум.

**Орон нутгийн санал:** Архангай аймгийн Булган сумын Засаг даргын 2022 оны 05-р сарын 12-ны өдрийн 01/199 дугаар албан бичиг болон /E-Mongolia/ **О99-2205-000642** дугаартай цахимаар ирүүлсэн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт зэргийг харгалзан үзэв. ҮГА-ын 2022.05.17-ны өдрийн Н-42 дугаар тушаал.

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар	
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох	
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм				
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	Хууриар хоргилсон, хязгаарлсан газар байгаа эсэхийг нарийвчилсан үнэлгээний шатанд тодорхойлох	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх			Тийм		
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				Тийм	
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх				Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	<b>Агаарын чанар</b>					
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх				Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх				Тийм	
	<b>Усан орчин</b>					
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх				Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх				Тийм	

	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	<b>Хөрсөн бүрхэвч</b>				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	<b>Ургамлан нөмрөг</b>				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
	<b>Амьтны аймаг</b>				
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм	
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	<b>Нутгийн оршин суугчид</b>				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм	
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
	<b>Түүх, соёлын биет өв</b>				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
	<b>Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл</b>				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм	
	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм	
<b>Нэгдсэн дүгнэлт:</b>					
Архангай аймгийн Булган сумын нутагт орших XV-65000022 /2021/002X/ тусгай зөвшөөрөлтэй “Авхайн булагийн элс-хайрганы ордыг ил аргаар ашиглах” төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.					
<b>Онцгойлон анхаарах зүйлс:</b>					
1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;					
2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /агаар, ус, хөрс, амьтан, ургамал г.м/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг тооцож, нийлбэр үнэлгээг гарган уг төслийн экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар дүгнэлт гаргах;					
3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан нарийвчлан судалж, эрх бүхий байгууллагаар усны нөөцийн дүгнэлт гаргуулах;					
4. Төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлыг хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг нарийвчлан тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;					
5. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тооцож, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухай бүс нутагт орших эвдрэлд					



- орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх замаар биологийн олон янз байдлын амьдрах орчныг сэргээхээр саналыг боловсруулж, шаардагдах зардлыг тайланд тусгах;
6. УУХҮ-ын болон БОАЖ-ын Сайд нарын 2019 оны 8-р сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар тушаалаар батлагдсан "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-ын дагуу Ордын ашиглалт дууссаны дараах хаалтын нөхөн сэргээлт, мониторинг хийх төслийг боловсруулж, хаалтын ажлын каледарчилсан төлөвлөгөө, зардлын тооцоог урьдчилан тооцож, тайланд тусгах;
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;
8. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 10<sup>1</sup>-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
9. Уг төсөл хэрэгжиснээр байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх зэрэг, сөрөг нөлөөллийн талаар болон эцэслэн боловсруулсан БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих баг/хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсарган саналыг тусгах;
10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа БОАЖЯ-наас авч тайланд хавсаргах.
11. Батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийн тушаал, дүгнэлтийг тайланд хавсаргах.
12. Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан "Тусгай зориулалтаар авто зам, замын байгууламж барих, ашиглах журам"-ын хэрэгжилтийг хангаж байгаа талаар тусгайлан дүгнэлт гаргаж, нарийвчилсан үнэлгээний тайланд тусгах.
13. Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн хүчин чадалд тулгуурлан мод тарих, модний төрөл зүйл, тоо хэмжээг тайланд тусгах;
14. Усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээг шинэчлэн байгуулж тайланд хавсаргах;
15. Мэдээллийн санд бүртгэлгүй жижиг гол, горхи, гүний усны нөөцтэй давхцалтай эсэх талаар судалж тайлан тусгах, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;

**Бусад зүйлс:**

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг тухай бүрт ханган биелүүлэх;
2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаан хэрэгжүүлэх;
3. Төслийн хүчин чадал, техник, технологит өөрчлөлт орсон тохиолд ерөнхий үнэлгээнд тухай бүрт хамрагдаж шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай болно.

**Дээрх дурьдсан арга хэмжээг цаг хугацаанд ханган биелүүлээгүй тохиолдолд Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, "Зөрчлийн тухай" хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.**

Ерөнхий үнэлгээ хийсэн:  
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
 ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ**  
 Гарын үсэг:



**О.АМАРСАНАА**

Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн:  
**"БОДЬ АР" ХХК -НИЙ ЗАХИРАЛ**  
 Гарын үсэг:



**Т.АЛТАНГЭРЭЛ**



БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ОРХОН-ЧУЛУУТ ГОЛЫН САВ  
ГАЗРЫН ЗАХИРГАА

2 дугаар баг, Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139

Утас/Факс: (976) 7033 3764,

Цахим шуудан: orkhonchuluut@gmail.com

АХЗ. 10.26 № 118

танай АХЗ. 10.97 -ны № 23/16 -Т

БОДЬ-АР ХХК-Д

